

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	Ч.Чулуунгэрэл	Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
	А.Ганпүрэв	Инженерийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
Гишүүд	Р.Дуламжав	иргэн /зөвшилцсөнөөр/
	Н.Даваасамбуу	иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Б.Баялаг	Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Ч.Чулуунгэрэл)-д даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгийг нэгтгэн архивын нөхөн бүрдүүлэлт хийж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны Нарийн бичгийн дарга (Б.Баялаг)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэст үүрэг болгосугай.

ХЯНАСАН ДАРГА

Ж. БОЛОРТУЯА

БОЛОВСРУУЛСАН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.ХОРОЛСҮРЭН

